



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/129/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Чойбалсан хот
2020 он

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: В.Цэнгэлмаа
Утас: 7058-4204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn
Аудитор: О.Эрдэнэтуяа
Утас: 7000-3775 Цахим хаяг: edi_7855@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НӨАТТХ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль



Агуулга

Аудитын гэрчилгээ	3
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
3.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
3.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
3.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
3.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан	15
3.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	16



**ХӨЛӨНБУЙР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ө.ШҮРЭНЧИМЭГ ТАНАА**

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөлөнбуйр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөлөнбуйр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хөлөнбуйр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалтын дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.1. Оршил

Хөлөнбуйр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Ө.Шүрэнчимэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөлөнбуйр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөлөнбуйр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 15-наас 2020 оны 02 дугаар сарын 19-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн гэрээт аудитор О.Эрдэнэтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Хөлөнбуйр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хөлөнбуйр сумын ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, бие даан ажиллаж амьдрах чадвартай болгон төлөвшүүлэх”-д оршино.

Хөлөнбуйр сумын ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- суралцагчдад боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх
- хүүхдийн хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Хөлөнбуйр сумын ерөнхий боловсролын сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна. Хөлөнбуйр сумын ерөнхий боловсролын сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд AXPLORER программ хангамж ашигладаг байна.

Хөлөнбуйр сумын ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хөлөнбуйр сумын ерөнхий боловсролын сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 32 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 520,248.7 мянган төгрөгөөс тооцон 7,804.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, гүйцэтгэлийн үе шатанд хэвээр баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хөлөнбуйр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,613.0 мянган төгрөгөөр буюу 0,9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	55.9	158.4	102.5
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	48,483.2	55,579.9	7,096.7
Үндсэн хөрөнгө	1,356,864.4	1,405,834.9	48,970.5
Элэгдэл	-141,927.7	-208,710.4	-66,782.7
Нийт хөрөнгө	1,263,475.8	1,252,862.8	-10,613.0
Өр төлбөр	1,134.6	0	-1,134.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,262,341.2	1,252,862.8	-9,478.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,263,475.8	1,252,862.8	10,613.0

Авлага дансны үлдэгдэл өссөн нь тус байгууллага “Жи мобайл” ХХК-тай хамтын гэрээгээр ажилчдаас суутгах суутгалыг илүү тооцоноос шалтгаалсан.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь спорт заалны гадна болон дотор талд гэрэлтүүлэг хийж 3,258.5 мянган төгрөгийн бараа материалыг орлогод авсан, мөн Боловсрол соёл урлагийн газраас 3,838.2 мянган төгрөгийн ном үнэ төлбөргүй өгснөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь орон нутгийн хөгжлийн сангаас 35,740.5 мянган төгрөгийн хичээлийн 1-р байрны халаалтын систем, Жүдо бөхийн холбоо ТББ-аас 10,160.0 мянган төгрөгийн жүдо бөхийн дэвжээг үнэ төлбөргүй хүлээн авч, батлагдсан төсвөөс 3,070.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авсантай холбоотой байна.

Биет бус хөрөнгө 2019 оны жилийн эцсийн тайлангаар өөрчлөлт ороогүй болно.

Өр төлбөр дансны үлдэгдэл нь 2018 оны жилийн эцсийн тайланд 1,134.6 төгрөг байсныг холбогдох байгууллагуудад төлж 2019 оны жилийн эцэст өр төлбөрийн үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,252,862.8 мянган төгрөг болж 10,613.0 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлээс шалтгаалжээ.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 456,107.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 404,107.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжих тусгай зориулалтын шилжүүлгээр, 52,000.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 3.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон малын ашиг шимээс 4,629.6 мянган төгрөгийн нэмэлт төсвийг бүрдүүлжээ.

Үүнээс малчны цалинд 1,920.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 240,0 мянган төгрөг, ном хэвлэл худалдан авахад 58,6 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 2,411.0 мянган төгрөг нийт 4,629.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 32 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 32 эрсдэл тодорхойлж нийт 32 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 75,845.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 433.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 75,412.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

Нийт худалдан авалтын 89,5 хувь буюу 72,7 сая төгрөг нь татварын нэгдсэн цахим хуудас дахь ибаримт системд бүртгэгдээгүй байна. Энэ нь үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

2. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

Түлш халаалтын зардлаас бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс 624.4 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардлаас бараа материал худалдан авахад 1,500.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардлаас томиллолтод 60.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. Энэ нь *Төсвийн тухай хуулийн 22.1 “Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана.” 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”* гэсэн заалтуудад нийцэхгүй санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

3. Худалдан авалт, гэрээний биелэлт, хэрэгжилт

Хүүхдийн хоолны материал худалдан авахдаа гэрээнд заасан үнээс илүү үнээр худалдан авч 937.7 мянган төгрөг зарцуулсан нь анхны гэрээнд тусгасан үнийг нийлүүлэгчийн ирүүлсэн албан тоотыг үндэслэн нэмсэнтэй холбоотой байна. Энэ нь *Төсвийн тухай хуулийн 41.2.3 “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу*



хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтад нийцэхгүй санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

Захирлын 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн Б/16 тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан ажилтанд шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад 433.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 41.2.3 “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” заалтад нийцэхгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хөлөнбуйр сумын Ерөнхий боловсролын сургууль нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 131 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хөлөнбуйр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Ерөнхий боловсролын сургууль 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

СТ-1А

3.1 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>48,539,119.40</u>	<u>55,738,284.40</u>
32120	Гадаад валют		

33	АВЛАГА	55,881.00	158,400.00
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/		
335	Бусад авлага	-	158,400.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	158,400.00
35	БАРАА МАТЕРИАЛ	48,483,238.40	55,579,884.40
354	Хангамжийн материал	34,863,238.40	41,664,884.40
35410	Бичиг хэргийн материал	1,919,480.00	2,009,480.00
35420	Аж ахуйн материал	32,573,758.40	35,817,194.40
35460	Хүнсний материал	-	10.00
35470	Бусад хангамжийн материал	-	3,838,200.00
35600	Мал амьтад	13,620,000.00	13,915,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,214,936,717.22</u>	<u>1,197,473,622.60</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,214,936,717.22	1,197,473,622.60
392	Биет хөрөнгө	1,173,733,217.02	1,156,340,122.36
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,051,550,531.70	1,087,640,170.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	(33,435,000.00)	(65,198,455.80)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	88,264,651.70	88,264,651.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	(46,609,967.10)	(61,563,610.19)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	66,658,171.33	67,808,171.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	(33,498,401.81)	(42,536,435.35)
39214	Бусад үндсэн хөрөнгө	102,755,120.00	114,835,120.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(27,981,815.80)	(38,939,417.03)
39217	Ном	6,029,927.00	6,029,927.00
393	Биет бус хөрөнгө	41,203,500.20	41,133,500.24
39301	Програм хангамж	700,000.00	700,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(402,499.80)	(472,499.76)
39303	Бусад биет бус хөрөнгө	40,906,000.00	40,906,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,263,475,836.62</u>	<u>1,253,211,907.00</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,134,619.00</u>	<u>0.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,134,619.00	0.00
413	Өглөг	1,134,619.00	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	386,958.00	0.00

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,262,341,217.62</u>	<u>1,253,211,907.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,262,341,217.62	1,253,211,907.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	342,647,827.23	342,647,827.23
51101	Өмч: - төрийн	342,647,827.23	342,647,827.23
512	Хуримтлагдсан үр дүн	331,124,378.34	321,995,067.72
51210	Өмнөх үеийн үр дүн	331,124,378.34	331,124,378.34
51220	Тайлант үеийн үр дүн	-	(9,129,310.62)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	588,569,012.05	588,569,012.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,263,475,836.62</u>	<u>1,253,211,907.00</u>

СТ-2А

3.2 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	536,229,664.50	521,904,439.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	149,499,944.50	14,918,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	149,499,944.50	14,918,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	149,499,944.50	14,918,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	149,499,944.50	14,918,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	386,729,720.00	506,986,239.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	377,304,600.00	450,356,639.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	-	46,249,639.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	377,304,600.00	404,107,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,425,120.00	4,629,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,820,120.00	4,629,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	52,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	52,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	435,775,285.51	520,248,749.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	435,775,285.51	520,248,749.62

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	407,209,607.55	506,391,270.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	243,763,611.00	310,572,030.73
210101	Үндсэн цалин	243,518,291.00	310,572,030.73
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,385,073.04	40,813,132.27
210201	Тэтгэврийн даатгал	20,683,330.98	27,996,685.86
210202	Тэтгэмжийн даатгал	2,457,351.55	3,232,601.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,941,357.06	2,557,921.45
210204	Ажилгүйдлийн даатгал	482,093.95	638,720.29
210205	Эрүүл мэндийн даатгал	4,820,939.50	6,387,202.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,085,816.00	43,200,000.00
210301	Гэрэл, цахилгаан	5,758,139.00	5,569,267.00
210302	Түлш, халаалт	38,099,952.00	36,488,544.00
210303	Цэвэр, бохир ус	227,725.00	1,142,189.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,064,600.00	10,113,540.00
210401	Бичиг хэрэг	1,821,900.00	1,944,400.00
210402	Тээвэр, шатахуун	938,000.00	3,841,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	772,000.00	1,494,000.00
210404	Ном, хэвлэл	-	258,640.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,532,700.00	2,574,700.00
2105	Нормативт зардал	22,700,365.00	24,341,610.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	250,000.00	900,000.00
210502	Хоол, хүнс	21,925,365.00	22,441,610.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	525,000.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	260,000.00	6,811,324.00
210604	Урсгал засвар	260,000.00	6,811,324.00
2107	Томилолт, зочны зардал	490,000.00	1,000,000.00
210702	Дотоод албан томилолт	490,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	180,000.00	410,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	230,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	57,280,142.51	69,129,633.62
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,346,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	56,680,142.51	66,782,733.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,565,677.96	13,857,479.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,248,565.00	13,856,910.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,681,765.00	13,856,910.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,317,112.96	569.00

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,317,112.96	569.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	100,454,378.99	1,655,689.38
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	341,409,677.66	10,785,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	11,295,320.00	10,785,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(341,409,677.66)	(10,785,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(240,955,298.67)	(9,129,310.62)

СТ-3А

3.3 АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	386,729,720	460,736,600
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	386,729,720	460,736,600
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	377,304,600	404,107,000
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	377,304,600	404,107,000
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,425,120	4,629,600
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,820,120	4,629,600
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	52,000,000
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	52,000,000
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	381,504,720	460,736,600
21	УРСГАЛ ЗАРДАЛ	381,504,720	460,736,600
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	353,840,907	446,435,400
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	244,948,297	313,100,800
210101	Үндсэн цалин	183,944,001	238,493,000
210102	Нэмэгдэл	26,549,692	37,294,800
210104	Урамшуулал	13,722,753	37,313,000
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,236,600	39,137,600



Хөлөнбуйр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210201	Тэтгэврийн даатгал	19,547,100	26,690,100
210202	Тэтгэмжийн даатгал	2,422,300	3,111,700
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,938,000	2,489,800
210204	Ажилгүйдлийн даатгал	484,300	622,600
210205	Эрүүл мэндийн даатгал	4,844,900	6,223,400
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,799,866	44,700,000
210301	Гэрэл, цахилгаан	8,558,139	7,069,267
210302	Түлш, халаалт	38,014,002	36,488,544
210303	Цэвэр, бохир ус	227,725	1,142,189
2104	Хангамж, бараа материалын зардал	4,736,650	10,807,340
210401	Бичиг хэрэг	853,500	1,850,000
210402	Тээвэр, шатахуун	735,950	3,471,800
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	772,000	1,494,000
210404	Ном, хэвлэл	120,000	258,640
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,255,200	3,732,900
2105	Нормативт зардал	23,716,694	24,543,800
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	250,000	900,000
210502	Хоол, хүнс	22,941,694	22,381,800
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	525,000	1,262,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,739,800	9,710,960
210602	Тавилга	-	900,000
210604	Урсгал засвар	1,739,800	8,810,960
2107	Томилолт, зочны зардал	490,000	1,000,000
210702	Дотоод албан томилолт	490,000	1,000,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	180,000	410,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	230,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000	180,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,993,000	3,024,900
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	888,000	250,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,105,000	2,774,900
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	27,663,813	14,301,200
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,346,700	14,300,631
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,779,900	14,300,631
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,317,113	569
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,317,113	569
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00



9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

СТ-4А

3.4 АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	342,647,827.23	588,569,012.05	331,124,378.34	0.00	1,262,341,217.62
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	342,647,827.23	588,569,012.05	331,124,378.34	0.00	1,262,341,217.62
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	342,647,827.23	588,569,012.05	331,124,378.34	0.00	1,262,341,217.62
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	342,647,827.23	588,569,012.05	331,124,378.34	0.00	1,262,341,217.62
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	342,647,827.23	588,569,012.05	331,124,378.34	0.00	1,262,341,217.62
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-9,129,310.62	0.00	-9,129,310.62
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	342,647,827.23	588,569,012.05	321,995,067.72	0.00	1,253,211,907.00

3.5 АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	456,107,000.00	456,106,431.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	456,107,000.00	456,106,431.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	441,805,800.00	441,805,800.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	311,180,800.00	311,180,800.00
210101	Үндсэн цалин	236,573,000.00	236,573,000.00
210102	Нэмэгдэл	37,294,800.00	37,294,800.00
210104	Урамшуулал	37,313,000.00	37,313,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,897,600.00	38,897,600.00
210201	Тэтгэврийн даатгал	26,450,100.00	26,450,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,111,700.00	3,111,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,489,800.00	2,489,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	622,600.00	622,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,223,400.00	6,223,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,700,000.00	44,700,000.00
210301	Гэрэл, цахилгаан	6,700,000.00	7,069,267.00
210302	Түлш, халаалт	37,000,000.00	36,488,544.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,142,189.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,668,700.00	10,668,700.00
210401	Бичиг хэрэг	1,850,000.00	1,850,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,391,800.00	3,391,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,494,000.00	1,494,000.00
210404	Ном, хэвлэл	200,000.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,732,900.00	3,732,900.00
2105	Нормативт зардал	24,543,800.00	24,543,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	900,000.00	900,000.00
210502	Хоол, хүнс	22,381,800.00	22,381,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,262,000.00	1,262,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,300,000.00	7,300,000.00
210604	Урсгал засвар	7,300,000.00	7,300,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.00	1,000,000.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	1,000,000.00



Хөлөнбуйр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	410,000.00	410,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	230,000.00	230,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,104,900.00	3,104,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	250,000.00	250,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,854,900.00	2,854,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,301,200.00	14,300,631.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,301,200.00	14,300,631.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,301,200.00	14,300,631.00

